

БИДНИЙ НИЙГЭМ ДЭХ ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

SOME OF THE PROBLEMS IN OUR SOCIETY



Д.Энхтайван

Дотоод хэргийн их сургуулийн

Хилийн албаны сургуулийн

Сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, хошууч

Товч утга: Нийгмийн хөгжлийг дагаад урган гарч буй сөрөг асуудлын талаар судлан үзнэ.

Түлхүүр үгс: Нийгэм, нийгмийн сэтгэл зүй, хандлага.

Abstract: Following the development of society, we will explore the negative issues that arise.

Keywords: Social, social psychology and attitudes.

Бид сүүлийн жилүүдэд ард иргэдийн санаа сэтгэлийг багагүй зовоон нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй цөөнгүй асуудлуудыг хамтран судалж дүн - шинжилгээ хийсний үр дүнд тухайн цаг үетэйгээ холбоотойгоор, "Төрийн тогтворгүй байдал", "Байгалийн гамшиг", "Корона", "Цаг уурын өөрчлөлт", "Цөлжилт"-ийн асуудал зэрэг сэтгэл зовоосон цаг зуурын шинжтэй асуудлууд өндөр хувьтай гарч байгаа бөгөөд үүнийг статистикийн мэдээлэл болон төрөл бүрийн чиглэлээр хийгдсэн судалгаануудаас давхар олонтаа олж үздэг.

Эдгээрээс байнга өндөр хувьтай гардаг бөгөөд манай нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй олон хүчин зүйлүүдийн суурь үндэс нь:

- **Ажилгүйдэл**
- **Ядуурал**
- **Архидалт** гурав юм.

Үүнээс үзвэл энэхүү гурван асуудал нь нийгмийн хувьд хамгийн тулгамдсан, суурь шинжтэй, нэн тэргүүнд анхаарах ёстой асуудлууд болж байна. Иймд эдгээрийг дангаар нь биш цогцоор шийдвэрлэх нэн шаардлагатай чухал асуудал хэмээн үзэж байна. (Хүснэгт 1.)

Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлийн зорилго нь дээрх асуудлуудын онцлог шинж, хамаарлыг гаргахын зэрэгцээ ажилгүйчүүдийн тоог бууруулахад нийгмийн хүчин зүйлийг гол болгон бодит нөхцөлд судлан үзэж түүнийг

бууруулах шинэлэг арга замыг дэвшүүлснээр хангагдана. Судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байгаа болно.

- Нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлсийг илрүүлж тогтоох;
- Өнөөгийн ажилгүйдлийн хэлбэр, тархалтад нөлөөлөх нөлөөллийг судлах;
- Ажилгүйдлийг бууруулах зарим арга замыг дэвшүүлэх;
- Ажилгүйдэл, Ядуурал, Архидалтыг цогцоор нь шийдвэрлэх боломж.

Мөн санал – асуулга авч, харьцуулалт хийхийн зэрэгцээ судалгааны баримтад задлан шинжилгээ хийх математик – статистикийн арга болон хоорондын хамаарлыг Юлийн коэффициентээр бодож гаргахад:

Таны санааг зовоож байгаа асуудлууд *Хүснэгт 1*

	Асуудлууд	2010 ¹⁴⁹	2016 ¹⁵⁰	2020 ¹⁵¹	2022 ¹⁵²
1	Тэнүүлчлэл	17,3	11,5	-	-
2	Халдварт өвчин	-	26,0	-	-
3	Байгалийн гамшиг	28,1	31,1	36,3	-
4	Ажилгүйдэл	45,2	45,6	66,7	29,5
5	Ядуурал	51,2	51,9	50,4	27,9
6	Архидалт	54,7	45,9	52,6	10,3
7	Авлига	19,5	-	12,3	7,3
8	Гэмт хэргийн өсөлт	30,6	36,9	14,2	-
9	Татварын ачаалал	-	-	-	-
10	Үнийн өсөлт	-	-	-	-
11	Төр засгийн байдал	38,3	33,3	-	-
12	Хүний эрхийн зөрчил	-	-	12,7	-
13	Хүнд суртал	-	-	18,0	-
14	Бусад	2,6	2,7	1,7	25

Одоогийн нөхцөл: Дээрх гурван асуудлыг гүнзгийрүүлэн судлахад өөр хоорондоо салшгүй холбоотой, бие биедээ харилцан нөлөөлдөг төдийгүй цогцоороо нийгмийн бусад тулгамдсан асуудлуудыг үүсгэж тэдгээрийг тодорхойлох үндсэн хүчин зүйл болдог. Нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхдээ цаад мөн чанарыг нь таньж, түүнийг нөхцөлдүүлэгч шалтгааныг

¹⁴⁹ “УИХ-ын сонгууль 2012” Удирдлагын академи. Түүвэр 600

¹⁵⁰ “Ерөнхийлөгчийн сонгууль 2016” Удирдлагын академи. Түүвэр 500

¹⁵¹ “Эдийн засгийн боловсрол” 2020 он, МУИС-ийн Эдийн засгийн сургууль

¹⁵² “Нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал” 2022 он. Түүвэр 850

эхлээд тодруулах учиртай. Шалтгааныг тогтоосны дараа шийдвэрлэх арга замаа сонговол илүү оновчтой, үр дүнтэй байдгийг практик бидэнд хэдийнээ харуулсан.

Эдгээр асуудлуудын хамаарлыг гаргаж нийгмийн бусад хүчин зүйлүүдэд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг илрүүлэн гаргах оролдлогыг эрэлхийллээ. Дээрх санаа зовоож буй асуудлуудын хооронд хамаарал байна уу? гэдгийг тогтоохын тулд тэдгээрийн хоорондын корреляцийн коэффициентийг бодож үзэв.

Корреляцийн матриц Хүснэгт 2

№		Ажилгүйдэл	Ядуурал	Архидалт	Гэмт хэргийн	Авлига	Татварын ачаалал	Байгалийн гамшиг	Үнийн өсөлт	Тэнүүчлэл
1	Ажилгүйдэл	1	0,583	0,578	0,402	0,105	0,119	0,108	0,023	0,165
2	Ядуурал	0,583	1	0,675	0,197	0,149	0,279	0,301	0,228	0,383
3	Архидалт	0,578	0,675	1	0,785	0,125	0,096	0,101	0,131	0,087
4	Гэмт хэргийн өсөлт	0,402	0,197	0,785	1	0,302	0,107	0,183	0,203	0,312
5	Авлига	0,105	0,101	0,125	0,302	1	0,383	0,211	0,245	0,017
6	Татварын ачаалал	0,119	0,279	0,096	0,107	0,383	1	0,133	0,421	0,075
7	Байгалийн гамшиг	0,108	0,301	0,101	0,183	0,211	0,133	1	0,210	0,165
8	Үнийн өсөлт	0,023	0,228	0,131	0,203	0,245	0,421	0,210	1	0,078
9	Тэнүүчлэл	0,165	0,383	0,087	0,312	0,017	0,075	0,165	0,078	1

Шинж тэмдгүүдийн хоорондын хамаарлыг Юлийн коэффициентоор бодож гаргав.

Ийм учир ажилгүйдэл, ядуурал¹⁵³, архидалт гурвыг нийгмийн хөгжилд саад болж байдаг **“Хар гурвалжин”** гэж нэрлэсэн юм.

Онцлон авч үзсэн асуудлуудын оршин байгаа хэлбэр болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг авч үзвэл:

Ажилгүйдэл нь:

- Гологдсон ба шоовдор ажилгүйчүүд, цамаан ажилгүйчүүд гэх мэт ажилгүйчүүдийн янз бүрийн бүлгийг төрүүлэх;
- Архидалт гэмт хэрэг өсөх нөхцөлийг бүрдүүлдэг;
- Эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлнө
- Хөдөөнөөс хот уруу шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлдэг г. м

¹⁵³ Илтгэлийн хүрээнд ядуурал гэсэн ойлголтын доор голчлон орлогын ядуурлыг авч үзсэн болно. Учир нь дээрх судалгаануудад оролцогчид ядуурлыг ихэвчлэн орлогын ядууралтай холбон авч үзсэн байна. Нөгөө талаас орлогын ядуурал нь оюуны ядуурал, чадавхийн ядуурал, улмаар үе дамжсан ядууралд хүргэдэг суурь мөн гэж үзэж байна.

Ядуурал нь:

- Бэлэнчлэх сэтгэлгээг;
- Авлига хээл хахууль;
- Урт хугацааны ядуурал, улмаар үе дамжсан ядууралд хүргэх;
- Нийгмийн социаль хүрээнээс салгах;
- Боловсронгүй хүмүүс г. м

Архидалт нь:

- Гэмт хэрэг;
- Эрүүл мэндийн хохирол;
- Гэр бүлийн хүчирхийлэл г. м

Архидалттай хийж буй тэмцэл

Архидалттай тэмцэх олон янзын арга хэмжээ авч байгаа ч өнөөгийн түвшингөөс харахад маш олон сөрөг асуудлуудыг бий болгож байна. Архидалттай тэмцэхэд үйлчилгээний газруудыг 24 цагаас хойш согтууруулах ундаа зарахгүй, үйлчлэхгүй байх талаар Засгийн газрын тогтоол гарсан юм. Гэсэн ч энэ нь нууцаар архи зарах “дамлах” үзэгдлийг улам хөөрөгдөж байна. Урьд өмнөхөөс согтуугаар үйлдсэн гэмт хэрэг ихсэн, цагдаагийн газарт эрүүлжигч, эмнэлэгт согтуугаар хүргэгдэгсдийн тоо нэмэгдсээр байна. Түүнчлэн далд эдийн засаг буй болох, татвараас зайлсхийх зэрэг сөрөг үр дагаврыг араасаа дагуулах боллоо. Энэхүү байдал нь дараах экспертийн яриагаар батлагдсан юм.

... СБД-ийн Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх тасагт дунджаар хоногт 30 хүн ордог байсан бол сүүлийн саруудад хамгийн багадаа 30 хүн хоногт ордог болсон ба энэ нь хүмүүс гэртээ болон бусад газар агсан согтуу тавьснаас болж дуудлагаар баригдах гол үндэс нь хулгайн хямд архи их зарагдах болсон гэж СБД цагдаагийн хэлтсийн ажилтан хэлжээ.

Үүнээс архидалт гэмт хэрэг ахуйн хүрээнд гэр бүлийн хүрээнд шилжсэн зэрэг олон сөрөг үр дагаврыг нийгэмд учруулж байгаа.

Ядууралтай хийж буй тэмцэл Ядуурлыг бууруулах олон хөтөлбөр төсөл хэрэгжсэн. Гэтэл үр дүн нь харагддаггүй, харин ч ядуурал буураагүй нэмэгдсэн гүнзгийрсэн гэсэн дүгнэлт гардаг.

Одоогийн ядуурлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага хувь хүмүүсийн үйл ажиллагаа нь хүмүүст бэлэн мөнгө өгөх, хувцас бэлэглэх, гурил олгох, хичээлийн хэрэгсэл, ногооны үр, мал, өвс тэжээл өгөөгүй юм байхгүй ба энэхүү нэг удаагийн бэлэн тусламж ядуучуудад тухайн үед нь гал унтраахаас өөрөөр бодитой нөлөөлдөггүй бөгөөд харин ч тусламж авах гэсэн бэлэнчлэх сэтгэлгээг өөгшүүлдэг, энэ нь улмаар ядууралд хүргэх ядуурлыг гүнзгийрэхэд нөлөөлдөг гэж хэлж болно.

Ядуу өрх, орлого багатай өрх, өрх толгойлсон эхчүүд, эмзэг бүлгийн хүүхдүүд, ядуу хүүхдүүд гэх мэтээр хаяглан тусламж олгох болсноор уг тусламжаас хүртэх гэсэн хүмүүсийн тоо механикаар өсдөг байна. Үүний зэрэгцээ айл өрхийг ядуу, орлого багатай амьдралын боломжгүй хэмээн тэднийг бусдаас улам хөндийрөх, нийгмээс тусгаарлагдах социал зайг үүсгэдэг гэж хэлж болно. Энэхүү социаль зай бий болсноос тэд өөрсдийн хамт олонгүй бэлэнчлэх сэтгэлгээтэй, өөрийн үнэлэмж үнэт зүйлсгүй, гутранги үзэлтэн бий болоход нөлөөлдөг.

Мөн тусламжийн ихэнх хэсэг нь зориулалтын бус хүмүүст очих явдал гардаг бөгөөд ядуурлаар бизнес хийж мөнгө олдог төрийн бус байгууллагууд, хувь хүмүүс байдаг нь нууц биш. Энэ талаар хийсэн судалгаанаас харвал иргэдэд олгож буй тусламж ихэнхдээ очих эзэндээ биш шат шатны дарга нарын хамаатан саданд очдог гэж судалгаанаас харагдаж байна. Тухайлбал Хэнтий аймагт авсан судалгаанд оролцогчдын 41,2 хувь нь дээрх хариултыг өгчээ.

Архидалттай тэмцэх, ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах ажлыг цогцоор шийдвэрлэж ажилгүйдлийг багасгахад чиглэх ёстой гэсэн санааг дэвшүүлж байна. Учир нь дээр өгүүлсэнчлэн энэ гурван асуудал салшгүй холбоотой, бие биедээ харилцан нөлөөлж байдгийн зэрэгцээ ажилгүйдэл нь илүү тодорхойлох шинжтэй хүчин зүйл болж байгаа юм.

Энэхүү илтгэлд “Хар Гурвалжин”-г “Алтан гурвалжин” болгоход нөлөөлөх байдлаар үзэж дан ганц асуудлыг эдийн засгийн талаас биш хүний хүчин зүйл, нийгмийн талаас нь хөндөхийг зорьсон болно.

Хэрхэн шийдэх вэ? Нийгмийн хөгжилд чөдөр тушаа болж буй гурван зүйлийг урвуу хэлбэрээр авч үзвэл ядуурал, архидалт хоёрын суурь үндэс нь ажилгүйдэл юм.

Та хэрвээ УИХ-ийн гишүүн байсан бол юуг нэн түрүүнд шийдэх вэ? гэсэн асуултад хариулсан байдлыг бүдүүвчид оруулав.

	Энгийн нийгэм		
Ядуурал	32.8%	19.5%	
	47.7%		
	Ажилгүйдэл		

Дээрх гурван хүчин зүйлийн нэн чухал нь 47,7 % нь ажилгүйдлийг шийднэ гэснээс харагдаж байна. Хөгжлийн энэхүү бүдүүвч нь урвуу хамааралтай болж дээшээ харсан нөхцөлд нийгэм хэвийн хөгжих бололцоотой болж байгаа юм.

Судалгааны явцад нийгмийн хөгжил болон дээрх бүдүүвчийг эргүүлж нийгмийн зүг харуулахад ажилгүйчүүдийн дараах хэлбэрүүдийг нэн тэргүүнд залуурдаж засах нь зүйтэй гэж үзэж байна. Өнөөдөр ажил эрхлэхийг хүсэж буй ажилгүй хүмүүс албан ёсны бүртгэлтэй ажилгүйчүүдийн тооноос хэд дахин илүү байгаа.

Хөгжлийн гурвалжинг Алтан гурвалжин болгох, урвууг эргүүлэхэд ажилгүйдлийн дараах хэлбэрүүдийг шийдвэрлэх нь чухал юм. Мөн сүүлийн жилүүдэд гологдсон буюу **Шоовдор ажилгүйчүүд** ихэссэн байна.

Хүмүүс:

- Нас
- Хүйс
- Биеийн хөгжил
- Царай зүс
- Танил тал
- Мэдлэг чадвар зэргээрээ гологдож ажилгүйчүүдийн эгнээнд орж байна.

Үүнийг 2019 оны эхний улирлын зарын сонинуудад хийсэн контент анализын дүнгээс харж болно.¹⁵⁴ Дээрх үзүүлэлтүүдийг тусгаж ажилд авна гэсэн зар нийт зарын 76% эзэлж байгаагаас өнөөгийн түвшинд царай зүс, нас хүйсээр нь ялгаварлах нь нийтлэг болох төлөв байдалтай байна.

Цамаан ба үнэ хүндийн ажилгүйчүүд: Энэхүү төрлийн ажилгүйчүүд сүүлийн жилүүдэд жин дарж байгаа нь илт байгаа. 2-3 их, дээд сургууль төгсчөөд хийх ажилгүй **“Бохир”** хэмээх ажил хийхгүй байна. **Та яагаад ажилд орохгүй байгаа вэ?** гэсэн асуултад 48% нь тухайн ажлын байрны орчин муу гэхэд, 39% нь ажлын нэр хүнд муу гэж хариулсан байна. Үүнээс харахад өнөөгийн залуучуудын өөрсдийн орон зайг мэдэрч хаана ажиллахаа олж чадаагүй байгаа нь цамаан ажилгүйчүүдийн тоонд орж байна.

Нэг талаас төр энэхүү ажиллаж, хөдөлмөрлөх нөхцөлийг илүү боловсронгуй болгох нь чухал тэрнээс ажил хийх сонирхолгүй биеийн амрыг бодоогүй байгаа нь судалгаанаас харагдсан.

Завсрын шинжтэй ажилгүйчүүд Энэ ажилгүйчүүдийн эгнээнд малчид, жижиг бизнес эрхлэгчид, ченж, хувиараа жижиг бизнес эрхлэгчид орж байгаа юм. Тэд өөрсдийнхөө хөдөлмөрийг эрхэлж тодорхой хэмжээний татвар төлөөд явж байгаа хэдий ч төрийн зүгээс буцаад авах дэмжлэг туслалцаа ямар нэгэн халамж үйлчилгээ хүртэхгүй байгаагаараа завсрын шинжтэй ажилгүйчүүдийн тоонд орж байгаа юм.

¹⁵⁴ “Шуурхай” сонин 2019 оны сүүлийн 3 сарын дугаарт контент анализ хийсэн.

...Сүүлийн жилүүдэд татвар нэмэгдэж байгаа, үйлчилгээ явуулахад хорооноос эхлээд бичиг баримт гээд хэцүү. Тэгсэн хэрнээ төрөөс бидэнд ямар нэгэн дэмжлэг туслалцаа байдаггүй энэ талыг л уламжлах хэрэгтэй байна.....

Чингэлтэй дүүргийн худалдагч

Амиа зогоогчид Эдгээр нь гар дээрээс наймаа хийж борлуулагч албан ёсоор бүртгүүлээгүй хулгайн журмаар ажил хийж хоолныхоо мөнгийг олдог хэдий ч төрөөс дэмжлэг авах боломжгүй далд эдийн засгийг бүрдүүлэгч нар орно. Зөвхөн өөрсдийнхөө л хэрэгцээгээ хангадаг.

Ажилгүйдлийг арилгах арга зам дээрх хэлсэнчлэн ядуурлыг бууруулах, архидалтыг багасгах үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ажилгүйдлийг бууруулах ажлын байр буй болоход чиглэгдэх ёстой. Ажил олгогч болон ажил хайгчдын хооронд зуучлах баазыг бий болгох нь нэн чухал.

Нэг талаас ажил олгогчдод найдвартай чадвартай ажилчид хэрэгтэй байдаг боловч тэднийг сонгож авах тал дээр алддаг боловсон хүчний бодлого дээр гаргадаг алдаа нь ажил олгогчдын гаргадаг үндсэн алдаа болж байна.

Энэ нь манай судалгаанд оролцсон хүмүүсээс та яагаад хөдөлмөрийн биржээр дамжуулж ажилтнаа авдаггүй юм бэ гэсэн асуултад энэ алба нь:

1. Төлөвшиж амжаагүй
2. Хүмүүс үйлчлүүлж сураагүй
3. Монгол хүмүүс ажилтнаар орох гэж байгаа хүнээ өөрөө харж үзэж сонгодог хэв маягт баригдсан.

Нөгөө талаас ажилд орохыг хүссэн ажилгүйчүүдийн боловсрол, мэргэжлийн түвшин, хөдөлмөрийн бүтээмж доогуур, хөдөлмөрийн сахилга бат тааруу, ажил тасалдаг, архи уудаг, хулгай хийдэг зэрэг дутагдал их гаргадаг.

Энэхүү зөрчлийг багасгаж зуучлах үүрэг, ажил хайгч, олгогч хоёрыг холбогч нь мэргэжлийн хүн байхыг шаардаж сүүлийн үед манайд ихээхэн үүрэг роль гүйцэтгэж байгаа **НИЙГМИЙН АЖИЛТАН** гүйцэтгэх ёстой гэсэн саналыг дэвшүүлж байна.

Гэхдээ энэ нь хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаанаас ялгаатай. Гол нь хүндээ чиглэсэн бодлогыг барьж байх ёстой.

Нийгмийн ажилтан байх давуу тал нь

- Монгол улсын хэмжээгээр нийт 70-80 гаруй нийгмийн ажилтан мэргэжлээр сэхээтнүүд төгсөж байгаа.
- Олон байгууллага болгон өөрсдийн Нийгмийн ажилтантай болсон.
- Хүний мөн чанар болон нийгмийн өмнө хүлээх эрх үүргийг сайн мэдэх.

- Ямар ч түвшний хүнтэй харилцах боломжтой.

Хүний эрхийг өндөрт тавьсан өнөөгийн нийгэмд ажлаасаа илүүтэйгээр хүнээ онцлон үзэж ажиллуулах, дадлагажуулах, голохгүй байх шаардлагыг төр засгаас хууль дүрэмд авч үзэх хэрэгтэй.

Эдийн засгийн хүрээнд хувийн хэвшил давамгайлах болсонтой холбоотойгоор ажилчдын эрх ашгийг хамгаалах шаардлага тулгарч байна. Өнөөдөр манай оронд хуульч эсвэл хуулийг сайн мэдэхгүй хүмүүс биш л бол хөдөлмөрийн хуулийн талаар ямар ч мэдлэггүй байгаа нь 2013 онд “Парадигм” клубээс авсан судалгаанаас харагдаж байна. Энэхүү судалгаанд төрийн захиргааны 5 байгууллага, хувийн аж ахуйн 10 байгууллагын 150 ажилчид оролцсон юм.

Та хөдөлмөрийн тухай хуулийг уншиж үзсэн үү, мэдэх үү гэсэн асуултад 68% нь үгүй буюу хараахан амжаагүй байна, харин та өөрийн ажлын дүрэм журамтай танилцсан уу гэхэд танилцаагүй буюу байхгүй гэж 53% нь хариулснаас өнөөгийн ажилчид хуулиа хэрхэн мэддэг нь харагдаж байна. Дээрх ажилтанд тулгарч байгаа асуудлыг хүртэл Нийгмийн ажилтан зохицуулж биелүүлж явах бүрэн боломжтой юм.

Ажилгүйдлийг арилгахад төрийн оролцоо яагаад бага байх ёстой вэ?

Ажлын байр бий болгоход төрийн оролцоог маш бага, төрийн бус байгууллагууд болон нийгмийн ажилтнуудын үүрэг оролцоог өндөр байлгах нь чухал. Төрийн оролцоо өндөр байх тусам энэ нь эргээд дээр дурдсан болон маш олон сөрөг үр дагаврыг авчирдаг. Угаасаа одоо байгаа оролцоо баталж гаргасан хууль, журам, дүрэм заавар нь энэ тал дээр хангалттай олон сөрөг үр дагаврыг төрүүлж хөгжилд чөдөр тушаа болж байна.

Жишээ нь: Ажлын байр буй болгох нэрийдлээр улсын болон тусламжийн, хандивлагчдын мөнгийг үр ашиггүй зарцуулах, эдгээрийг танил талдаа өгөх авлигал хээл хахуульд өртөх гэх мэт. Харин төрийн зүгээс:

Улс орныг хөгжүүлэх ажилгүйдлийг арилгах талаар макро болон микро түвшинд стратегийн бодлого, үйл ажиллагаа явуулахдаа:

- Ажил эрхлэлтийн байдлаар нь оюуны болон биеийн хүчний ажил хэмээн төрөлжүүлэн үйлчилгээ үзүүлж болно.
- Шоовдор ажилгүйчүүдийг дэмжих тэднийг нийгмийн ажилтнаар дамжуулан бусад байгууллагатай холбож өгөх
- Ажилгүйчүүдийг сургалт семинарт байнга хамруулж байх болно.

Ажилгүйдлийг арилгахад: Нийтийг хамарсан компанит ажилд ажилгүй ядуучуудыг татан оролцуулах, хог цэвэрлэх, хот тохижуулах, далан шуудуу татах, гал унтраах, хадлан тэжээл бэлтгэх, ойжуулах, мянганы зам гэх мэт. Энэ нь дор хаяж дараах ач холбогдолтой

1. Ажил хийвэл ам тосдоно гэдэг зарчмаар зүгээр сууж байгаад тусламж авдаг сэтгэлгээнээс салгах.

2. Нийтийг хамарсан ажлаар дамжуулж зарим нэг хөрөнгө оруулалт төслийн хэрэгжилтийг ядуучуудын орлогыг нэмэгдүүлэх тусламжийн хэлбэрт шилжүүлэх /ойжуулах ажлыг ажилгүйчүүдийн хүчээр хийх, ойжуулах төсөл хэрэгжихийн зэрэгцээ, ажилгүйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх бололцоотой болох/

3. Төслөөр дамжуулан ажил олгогч болон ажилгүйчүүдийг хооронд нь холбох

4. Нийтийг хамарсан ажлаар дамжуулж зарим ажилгүйчүүдийн хөдөлмөрт хандах хандлага, ажил мэргэжлийн бэлтгэлийг дээшлүүлэх

5. Ажлын байрны тоог нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

6. МСҮТ-ийн сургалтыг чанаржуулах энэ нь цамаан ажилгүйчүүдийн тоог багасгахад оршино.

Илтгэлтэй холбогдуулж дараах дүгнэлтийг хийж байна.

- Ажилгүйдэл, ядуурал, архидалт гэсэн 3 асуудлыг гүнзгийрүүлэн судлахад өөр хоорондоо салшгүй холбоотой, бие биедээ харилцан нөлөөлж байдаг, түүгээр ч зогсохгүй цогцоороо нийгмийн бусад тулгамдсан асуудлуудыг үүсгэдэг, тэдгээрийг тодорхойлдог үндсэн хүчин зүйл болдог ажээ.

- Монголын нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй Ажилгүйдэл, Ядуурал, Архидалт зэрэг асуудлуудыг дан дангаар нь биш цогцоор нь шийдвэрлэх нь нэн шаардлагатай төдийгүй илүү үр дүнтэй юм.

- Нийгмийн Ажилгүйдлийн хэлбэрийг судалж үзээд, гологдсон ба шоовдор ажилгүйчүүд, цамаан ажилгүйчүүд, завсрын шинжтэй ажилгүйчүүд, амиа зогоогч ажилгүйчүүд хэмээн хэв маягчилж болмоор байна гэж үзлээ.

- Ажилгүйдлийг бууруулахад нийгмийн ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна.

- Нийгмийн ажилтнуудыг дадлагажуулах сургалт семинарт хамруулж байх шаардлагатай.

- Ажилгүйчүүдийг бүх нийтийг хамарсан ажилд хамруулан хамт олны уур амьсгал бүрдүүлэн төлөвшүүлэх

- Төрийн бус байгууллагуудтай хамтарч ажилгүйдлийг арилгах шинэлэг замыг хайж тэдний оролцоо эрх мэдлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- Нийгмийн өмнө тулгамдсан эдгээр асуудлуудыг цаашид гүнзгийрүүлэн нарийвчлан судлах шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Ц.Пүрэв Социологийн мэдээллийг шинжлэх статистик арга УБ 2004 он
2. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг

3. М. Фридман, Р. Фридман Хувь заяагаа сонгах нь УБ 2001 он
4. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл УБ 2012, 2013 он
5. Социологи сэтгүүл-2, 3, 4
6. *Зууны мэдээ* сонины 2013-11-15 6 тал
7. Х.Гүндсамбуу Монголын нийгмийн давхраажилийн хөгжил хандлага УБ 2002 он
8. О. Лхагварэнцэн Далд эдийн засаг УБ 2008 он
9. Парадигм клубын судалгаа 2012-2014 он
10. Аймгуудад *Сонгууль*, *Авилгал*, *Иргэдийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал* гэх мэт цогц судалгаа 2012 он, 8-р сар / Хэнтий, Хөвсгөл, Архангай, Булган/

---o0o---